



СЭЛЭНГЭ АЙМАГ
БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/90

Баруун хараа

Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг
батлах тухай

Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 71 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2, 3.3 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/77 дугаар тушаалаар баталсан “Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчид тэтгэвэр тогтоолгох баримтлах журмын дагуу малчнаар ажиллаж байсан хугацааг тодорхойлох сумын засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Зөвлөлийн дарга:

Б.Эрдэнэбаатар Засаг даргын тамгын газрын даргын үүрэг
гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга:

О.Уламбаяр Нийгмийн даатгалын байцаагч

Гишүүд:

Л.Занданбат Хараа 1 дүгээр багийн Засаг дарга

Б.Түшигжаргал Баян 2 дугаар багийн Засаг дарга

Б.Болортуяа Гонир 3 дугаар багийн Засаг дарга

Ч.Даваадорж Малын эмч

Ө.Сувд-Эрдэнэ Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Г.Баясгалан Статистикийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Г.Нямсамбуу Иргэний төлөөлөл

2. Орон тооны бус зөвлөлд ДААЛГАХ нь:

2.1. 1991 оноос 2017 оны хоорондох “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн оны тооллого”-ын жил бүрийн бүртгэл “А” дансны судалгааг гаргаж тухайн багийн “А” данс нь хэдээс хэдэн оных бүрэн байгаа, “А” данс нь хэдээс хэдэн оных нь үрэгдэж олдохгүй байгааг баг тус бүрээр 2018 оны 5 дугаар сард багтаан гарган цахим санд бүртгэж баталгаажуулж авсан байх;

2.2. Сумын хэмжээнд мал маллаж байгаа нийт малчдын нэгдсэн бүртгэл судалгааг тухайн малчин өрхийн ам бүлд албан ёсны бүртгэлтэй гишүүдийн овог, нэрийг регистрийн дугаарын хамт гаргаж мэдээллийн нэгдсэн цахим санд бүртгэх ажлыг 2018 оны 5 дугаар сард зохион байгуулж дүнг нэгтгэсэн байх;

2.3. Малчны өндөр насны тэтгэврийг 2018-2020 онд тогтоолгох малчдын судалгааг баг тус бүрээр гарган, тэтгэвэр тогтоох баримт бичгийг бүрдүүлэх талаарх зөвлөгөө өгөх, дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг, багуудтай хамтран зохион байгуулах;

2.4. "Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн оны тооллого"-ын жил бүрийн бүртгэл "А" данс нь үрэгдсэн нь аймаг, сумын архивын бүртгэл, судалгааг/лавлагаагаар/-аар нотлогдож байгаа малчдын 1995 оноос хойш тухайн багт мал маллаж байсан хугацааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/77 дугаар тушаалаар баталсан " Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрэм"- ийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2-т заасан эрх, үүргийг чанд баримтлан хуулийн дагуу хянан хэлэлцэж хугацаанд нь шийдвэрлэж байх;

2.5. Зөвлөлийн гишүүдэд даатгуулагчийн 1995 оноос хойш малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг хууль тогтоомжийн дагуу хэрхэн үндэслэлтэй үнэн зөв тодорхойлох талаарх нэгдсэн удирдлагаар ханган ажиллах;

2.6. Зөвлөлийн бүх гишүүд нь "А" данс нь үрэгдсэн малчдын 1995 оноос хойш тухайн багт мал маллаж байсан хугацааг нь нотлох үндэслэл бүхий баримт бичигт тулгуурлан шударга зарчмыг баримтлан хууль тогтоомжид заасны дагуу тодорхойлж байх;

2.7. Зөвлөлийн бүх гишүүд мал маллаагүй өөрийн хамаарал бүхий төрөл садан, ах дүү даатгуулагчийг мал маллаж байснаар хуурамчаар тодорхойлохыг хориглох;

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/63 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С. АРИУНБАТ